



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2020.03
2020.03



ГАРЧИГ

Аргачлалын тайлбар	3-4
Хүн ам өрхийн зарим үзүүлэлт.....	5
Орон нутгийн төсвийн орлого, зарлага	5-6
Ажиллагсад, ажилгүйчүүд, ажлын байр	6
Мөнгө, банк.....	7
Үнэ.....	7-8
Аж үйлдвэр.....	8
Хөдөө аж ахуй	9-11
Нийгмийн даатгал, нийгмийн халамж.....	11-12
Эрүүл мэнд.....	12-13
Гэмт хэрэг.....	13-14

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Гэмт хэрэг:** Аймгийн цагдаагийн газраас захиргааны статистик мэдээгээр нэгтгэн гаргадаг.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

- Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



ХҮН АМ, ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС

			Үүнээс	Үүнээс
			Эм	Эр
Баянхонгор	Баацагаан сум	1 058	198	860
Баянхонгор	Баянбулаг сум	494	83	411
Баянхонгор	Баянговь сум	887	210	677
Баянхонгор	Баянлиг сум	1 075	211	864
Баянхонгор	Баян-Овоо сум	853	190	663
Баянхонгор	Баян-Өндөр сум	744	146	598
Баянхонгор	Баянхонгор сум	9 633	3 417	6 216
Баянхонгор	Баянцагаан сум	1 036	218	818
Баянхонгор	Богд сум	900	187	713
Баянхонгор	Бөмбөгөр сум	1 015	210	805
Баянхонгор	Бууцагаан сум	1 090	230	860
Баянхонгор	Галуут сум	1 253	238	1 015
Баянхонгор	Гурванбулаг сум	653	100	553
Баянхонгор	Жаргалант сум	905	209	696
Баянхонгор	Жинст сум	644	115	529
Баянхонгор	Заг сум	633	123	510
Баянхонгор	Өлзийт сум	1 147	250	897
Баянхонгор	Хүрээмарал сум	528	86	442
Баянхонгор	Шинэжинст сум	768	170	598
Баянхонгор	Эрдэнэцогт сум	1 297	271	1 026
Нийт		26 613	6 862	19 751

ХҮН АМЫН ТОО

Засаг захиргааны нэгж	2019			2018		
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Баянхонгор	89,253	43,974	45,279	88,359	43,530	44,829
Баянхонгор	32,297	15,399	16,898	31,685	15,127	16,558
Баацагаан	3,282	1,673	1,609	3,307	1,679	1,628
Баянбулаг	1,789	878	911	1,767	877	890
Баянговь	2,986	1,438	1,548	2,922	1,420	1,502
Баянлиг	3,860	1,906	1,954	3,848	1,906	1,942
Баян-Овоо	2,594	1,353	1,241	2,650	1,384	1,266
Баян-Өндөр	2,650	1,342	1,308	2,668	1,350	1,318
Баянцагаан	3,592	1,809	1,783	3,590	1,811	1,779
Богд	3,127	1,541	1,586	3,113	1,516	1,597
Бөмбөгөр	3,323	1,675	1,648	3,288	1,644	1,644
Бууцагаан	3,703	1,858	1,845	3,670	1,836	1,834
Галуут	4,112	2,138	1,974	4,103	2,122	1,981
Гурванбулаг	2,273	1,128	1,145	2,216	1,096	1,120
Жаргалант	2,901	1,443	1,458	2,961	1,474	1,487
Жинст	2,228	1,104	1,124	2,192	1,084	1,108
Заг	2,086	1,064	1,022	2,073	1,050	1,023
Өлзийт	3,845	1,926	1,919	3,870	1,945	1,925
Хүрээмарал	1,793	908	885	1,748	883	865
Шинэжинст	2,493	1,230	1,263	2,449	1,205	1,244
Эрдэнэцогт	4,319	2,161	2,158	4,239	2,121	2,118



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

2020 оны 03 дугаар сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 2994.6 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 258.7 сая төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна. 2020 оны 03 дугаар сарын нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Богд, Хүрээмарал, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Бууцагаан Баацагаан, Баянговь, Гурванбулаг, Жаргалант, Бөмбөгөр, Баянбулаг, Жинст сумууд давуулан биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: хог хаягдлын хураамж 14.7 сая төгрөг, агаарын бохирдол (авто) 6.1 сая төгрөгөөр тус тус тасарч, НӨАТатвар 45.2 сая төгрөг, ААНБ-ын орлогын албан татвар 50.5 сая төгрөг, ЦХТА орлого /суутган-1/ 197.8 сая төгрөг, Улсын тэмдэгтийн хураамж 7.8 сая төгрөгөөр тус тус давуулан биелэлээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 4.8 хувь, нэмүү өртгийн албан татвар 8.6 хувь, ЦХТА орлого 48.9 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 1.4 хувь, хүү торгууль 8.4 хувь. бусад төлбөр хураамж 9.4 хувийг тус тус эзэлж байна



МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Монгол Банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2020 оны 03 дугаар сарын 31-ны байдлаар арилжааны банкуудаар нийт зээлийн өрийн үлдэгдэл 183392.1 сая төгрөг байгаагийн 5219.8 сая төгрөг нь анхаарал хандуулах зээл /хугацаа хэтэрсэн/, 1864.9 сая нь чанаргүй зээл байна.

2020 оны эхний 3 сарын байдлаар нийт хадгаламжийн үлдэгдэл 113381.4 сая төгрөг болжээ. Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 113158.5 сая төгрөг, Үүний 21253.7 сая төгрөг нь хугацаагүй хадгаламж, 92127.7 сая төгрөг нь хугацаатай хадгаламж байна.

Нийт банкны салбар, нэгжийн тоо	54
Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо	252
Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)	38187
Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	143017
Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	72069
Нийт АТМ-ны тоо	56
Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо	62488



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Аймгийн өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс 03 сарын байдлаар өмнөх сартай харьцуулсанаар 0.9 хувиар өсчээ, ийнхүү өсөхөд голлож мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний барааны бүлгийн үнэ өссөн нь нөлөөлжээ.

Харин өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 2.9 хувиар өссөн нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны барааны бүлгийн үнэ, согтууруулах ундааны бүлгийн барааний үнэ өссөнтэй холбоотойгоор өссөн нь харагдаж байна.

Тайлант 03 дугаар сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ерөнхий индекс 6.2 хувиар өссөн байгаа нь голлож тээврийн бүлгийн барааны үнэ, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн барааны үнэ өссөнтэй шууд холбоотой байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

Барааны бүлгээр	2020.03	2020.03	2020.03
	2019.03	2019.12	2020.02
ЕРӨНХИЙ ИНДЕКС	106.2	102.9	100.9
ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	110.0	108.1	102.6
СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	107.3	103.7	100.4
СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	103.8	100.4	100.0
ТАМХИ	103.2	100.0	100.0
ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	108.5	102.2	100.8
ГУТАЛ	108.8	102.0	100.8
ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД	105.0	100.1	100.0
ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	101.4	100.2	100.0
УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	106.3	100.0	100.0

ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	106.8	100.0	100.0
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	103.4	100.8	100.2
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР	107.3	101.2	100.2
ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ	100.0	100.0	100.0
ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА	100.8	100.0	100.0
ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА	107.0	100.0	100.0
ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ	100.7	100.7	100.0
ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА, ГЭРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	101.9	101.3	100.4
ЭМ ТАРИА ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	103.8	100.0	100.0
ЭМ ТАРИА ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ	105.1	100.0	100.0
АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
ТЭЭВЭР	102.8	100.1	100.0
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ	101.4	100.0	100.0
ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ	104.4	100.0	99.9
ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	101.2	101.2	100.0
ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.4	100.0	100.0
АМРАЛТ ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	102.4	100.0	100.0
ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	100.6	100.0	100.0
ЧӨЛӨӨТ ЦАГ СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
НОМ СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ	106.1	100.0	100.0
БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
ЗОЧИД БУУДАЛ НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
БУСАД БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	105.0	100.5	100.1
ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ	105.1	100.6	100.2
ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ	106.1	100.0	100.0
САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны үнэ,сараар

Нэр төрөл	2019.03	2019.12	2020.03	2020.03
				2019.03
1-р зэргийн гурил	1200	1200	1300	108.3
Хонины мах, кг	6800	6200	8000	117.6
Үхрийн цул мах, кг	8500	9000	11000	129.4
Ямааны мах, кг	6000	5200	6800	113.3
Элсэн чихэр, кг	2000	2000	2000	100.0
Цагаан будаа, кг	2200	2200	2500	113.6
Шингэн сүү, л	3500	3000	4000	114.3
Цагаан ноолуур, кг	100000	60000	50000	50.0
Бор ноолуур, кг	100000	60000	50000	50.0
Бензин А-80, л	1805	1860	1800	99.7
Бензин АН-92, л	1835	1900	1840	100.3
Дизел түлш, л	2400	2580	2580	107.5



АЖ ҮЙЛДВЭР

2020 оны 03 дугаар сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 5744.8 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 1450.5 сая төгрөгөөр буюу 20.2 хувиар буурсан байна.

Нийт борлуулалт товчоо, салбараар

Салбар	Аж үйлдвэрийн борлуулалт (мян.төг)				
	2019		2020		<u>2020</u> <u>2019</u>
	III	I-III	III*	I-III*	III*
Нийт дүн	2191796	7195352.9	1503441	5744792.2	79.8
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1461645	5094081.5	546650.4	2848461.6	55.9
Боловсруулах аж үйлдвэр	54001.1	176864.8	95890.7	397485	224.7
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	676150.1	1924406.6	860899.9	2498845.6	129.9

Аж үйлдвэрийн нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2020 оны эхний 3 сарын гүйцэтгэл

Бүтээгдэхүүний нэрс	хэмжих нэгж	Биет хэмжээ				<u>2020</u> <u>2019</u>
		2019		2020		-
		III	I-III	III*	I-III*	III*
Уул уурхай, олборлох аж үйлдвэр						
Чулуун нүүрс	мян.тн	2.5	10.7	1.7	18.66	174.4
Алт	кг	14	48.6	4.913	24.213	49.8
Боловсруулах аж үйлдвэр						
Дулааны эрчим хүч	мян.Гкал	46.34	132.38	63.78	184.76	139.6
Хиам	тн	0.8	2.4	0.58	2.13	88.8
Боловсруулсан шингэн сүү	мян.л	0.36	1.505	0.34	1.329	88.3
Нарийн боов	тн	9.976	25.909	5.365	20.089	77.5
Талх	тн	12.84	27.009	9.775	27.809	103
Түгээсэн цэвэр ус	мян.м3	54.5	141.6	55.6	168.54	119



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал тооллогын дүнгээр 2019 оны жилийн эцэст манай аймгийн мал сүргийн тоо 4644.8 мянга болж, 2018 оныхоос 9.3 хувь буюу 395.3 мянган толгойгоор өссөн байна. Урьдчилсан дүнгээр адуун сүргийн тоо 189.5 мянга, үхэр сүрэг 257.6 мянга, тэмээн сүрэг 58.1 мянга, хонь 1406.0 мянга, ямаа 2733.7 мянган толгой болж нийт мал сүргийн тоо таван төрөл дээрээ өсчээ.

Нийт мал сүргийн дотор адуу 4.1 хувь, үхэр 5.5 хувь, тэмээ 1.3 хувь, хонь 30.3 хувь, ямаа 58.8 хувийг тус тус эзэлж, өмнөх оныхоос ямааны эзлэх хувь 0.5 пунктээр өсч, хониных 0.3 пункт, үхэр 0.1 пункт, тэмээнийх 0.1 пунктээр тус тус буурсан байна.

Малын тоо 2019 онд

	МЯН.ТОЛ					
	Малын тоо		2019/2018		Нийт дүнд эзлэх хувь	
	2018	2019	Зөрүү	Хувь	2018	2019
Бүгд	4249.5	4644.8	395.3	109.3	100.0	100.0
Адуу	175.9	189.5	13.6	107.7	4.1	4.1
Үхэр	239.8	257.6	17.8	107.4	5.6	5.5
Тэмээ	57.4	58.1	0.7	101.2	1.4	1.3
Хонь	1297.5	1406.0	108.5	108.4	30.6	30.3
Ямаа	2478.9	2733.7	254.8	110.3	58.3	58.8

Манай аймаг улсад нийт малын тоогоор 4644.8 мянган толгой малтай зургаад, ямааны тоогоор 2733.7 мянган толгой ямаатай нэгдүгээрт, тэмээний тоогоор 58.1 мянган толгой тэмээтэй хоёрдугаарт, үхрээр 257.5 мянган толгой үхэртэй есдүгээрт, адуугаар 189.5 мянган толгой адуутай аравт, хониор 1406.0 мянган толгой хоньтой арваннэгдүгээрт орж байна.

Хамгийн олон мал тоолуулсан эхний 5 сумд Баацагаан 368.3 мянган толгой, Галуут 309.6 мянган толгой, Бууцагаан 303.1 мянган толгой, Бөмбөгөр 299.6 мянган толгой, Өлзийт 277.5 мянган толгой мал тус тус тоолуулжээ.

Аймгийн хэмжээнд 03 дугаар сарын мал төллөлт, төл бойжилтийн мэдээгээр оны эхний хээлтэгчийн 34.6 хувь буюу нийт 681735 хээлтэгч мал төллөсөн ба гарсан төлийн 99.2 хувь буюу 676690 төл эсэн мэнд бойжиж байна. Бойжсон төлийг төрлөөр нь харвал ботго 2831, унага 656, тугал 5248, хурга 291472, ишиг 376483 толгой тус тус бойжсон байна.

2020 оны 03 дугаар сарын том малын зүй бус хорогдлын мэдээгээр нийт 6057 толгой мал хорогдсон нь оны эхний малын 0.13 хувийг эзлэж байна. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл тэмээ 11, адуу 301, үхэр 761, хонь 1829, ямаа 3155 толгой тус тус хорогджээ. Мөн нийт хорогдсон малын 16.4 хувь буюу 991 толгой хээлтэгч мал хорогдсон байна.



НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ

Оны эхний 3 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 9530.8 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэрт 2202.2 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 538.1 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 270.1 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 18.5 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 425.6 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 76.0 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 22.8 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 11.8 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 104.9 сая төгрөг тус тус олгожээ

Нийгмийн халамжийн сангаас эхний 3 сарын байдлаар нийт 3699.1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгож үүнээс жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй 1207 эхчүүдэд 39.1 сая төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж 7483 эхэд 975.1 сая төгрөг, алдар цолтой 24 ахмадад 11.1 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн бол Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж 221 хүнд 76.1 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 121 хүнд 26.2 сая төгрөг тус тус зарцуулсан байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР, АЖИЛЛАГСАД

Эхний 3 сард аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэд 548 болж өмнөх сараас 2.0 хувиар өсчээ. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 287 буюу 52.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-44 насныхан 78.5 хувь буюу 430 иргэн, 45 дээш насныхан 118 иргэн 21.5 хувийг эзлэж байна. Харин боловсролын түвшнээр харвал бүрэн дунд хүртэл боловсролтой иргэд 389 буюу 71.0 хувь, тусгай мэргэжлийн болон техникийн боловсролтой иргэд 51 буюу 9.3 хувь, дээд, магистр, докторын боловсролтой иргэд 108 буюу 19.7 хувийг тус тус эзлэж байна.

2020 оны 3 сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс 120 иргэн үүнээс 70 эмэгтэй ажилд зуучлагдан оржээ. Ажилд орсон иргэдийн 91 иргэн буюу 75.8 хувь нь 15-44 насныхан байна.

Шинэ ажлын байранд нийт 136 иргэн ажиллаж байгаа бөгөөд үүний 56.6 хувь буюу 77 эмэгтэйчүүд байна. Шинэ ажлын байранд ажиллаж байгаа иргэдийг эдийн засгийн салбараар харвал Хөдөө аж ахуйн салбарт 16, барилгын салбарт 1, Боловсруулах үйлдвэрийн салбарт 20, Худалдааны салбарт 13, санхүүгийн болон даатгалд 0, төрийн удирдлага болон албан журмын нийгмийн хамгаалалд 25, боловсролд 8, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 12, хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн үйл ажиллагаа салбарт 10 хүнд шинэ ажлын байр гаргаж ажиллаж байна.

Эхний 3 сарын байдлаар 181 ажлын байрны захиалга ирсэн байна. Ажлын байрны захиалгыг эдийн засгийн салбараар үзвэл Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалалд 16, Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 5, Хөдөө аж ахуйн салбарт 40, Барилгын салбарт 0, Боловсролын салбарт 14, Үйлчилгээний бусад үйл ажиллагаа 43, уул уурхай олборлолтын салбарт 0, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн салбарт 19, боловсруулах үйлдвэрлэлд 30, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 0, бусад салбаруудад 0-5 ажлын байрны захиалга иржээ.



ЭРҮҮЛ МЭНД

2020 оны 03 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд 497 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 23 төрөлтөөр өссөн байна. Нийт төрсөн эхийн 90.1 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын, сумын эмнэлэгт 9.9 хувь нь төржээ. Нялхасын эндэгдэл эхний 3 сарын байдлаар 6 гарчээ.

03 сарын байдлаар нийт 337 халдварт өвчин бүртгэгдэж 10,000 хүн амд 37.8 байгааг өнгөрсөн оны мөн үе(35.5)тэй харьцуулахад нэмэгдэж, сүрьеэгийн нэг нас баралт бүртгэгдсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад БЗДХ-ын тохиолдлын тоо 1.5 дахин буурч, нийт халдварт өвчний 77.1 хувийг эзэлж байна. Бүртгэгдсэн БЗДХ-ын 260 тохиолдлын 16.1 хувийг загхүйтэн, 58.1 хувийг трихомониаз, 25.7 хувийг тэмбүүгийн өвчлөл эзэлж байна

Аймгийн хэмжээнд эхний 3 дугаар сарын байдлаар нас баралтын 100 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 17 тохиолдлоор буурч, нийт нас баралтын 23.0 хувь нь эмнэлэгт нас барснаас 43.4 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс өссөн байна.

Нийт 4990 түргэн тусламжийн дуудлага бүртгэгдсэний 22.9 хувийг алсын, 1.7 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн дуудлага болон нийт дуудлаганд эзлэх алсын дуудлага нэмэгдэж, осол гэмтлийн дуудлага буурсан байна.



ГЭМТ ХЭРЭГ

1. 2020 оны I улиралд нийт 1114 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгав. Үүнээс:



239 буюу 21,4%

- ✓ 168 буюу 70,3 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн
- ✓ 32 буюу 13,3 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гаргасан.



860 буюу 77,2%

- ✓ 616 буюу 71,6 хувийг Зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдсэн
- ✓ 242 буюу 28,1 хувийг зөрчлийн шинжгүй үндэслэлээр татгалзсан
- ✓ 2 буюу 0.2 Харьяаллын дагуу шилжүүлсэн байна.


Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 169 буюу 70,7 хувийг 5 хоногт, 31 буюу 13 хувийг 6-19 хоногт, Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 846 буюу 98.3 хувийг 3 хоногт, 14 буюу 1.6 хувийг 4 ба түүнээс дээш хоногт тус тус шалгаж шийдвэрлэсэн.

2. Бүртгэгдсэн гэмт хэрэг:


Аймгийн хэмжээнд энэ оны I улиралд 152 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 70 нэгжээр буюу 31,5 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 75 буюу 49,3 хувь нь Баянхонгор суманд, 76 буюу 50 хувь нь бусад суманд үйлдэгдсэн.

Гэмт хэргийн гаралтыг багаар нь харьцуулсан байдал




Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал



Энэ хугацаанд хэрэг бүртгэлтийн 144 хэрэг бүртгэгдснээс 37 хэргийн холбогдогчийг яллагдагчаар татаж ял сонгосон. Нийт гэмт хэргийн илрүүлэлт 25.7 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5.5 пунктээр буусан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал:

Бүртгэгдсэн гэмт хэргийн 125 буюу 82.2 хувь нь хөнгөн ангилалын, 27 буюу 17.7 хувь нь хүнд ангилалын гэмт хэрэг бүртгэгдсэн.



2020 оны 3 сарын байдлаар /өссөн дүнгээр/

Хэргийн ангилал	2019 оны 3 сар	2020 оны 3 сар	Харьцуулалт	Хувь
Хүний амьд явах эрхийн эсрэг	6	7	1	16.6%
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	60	31	-29	-48.3%
Хүчиндэх	2	4	2	100%
Өмчийн хулгай	47	24	-23	-48%
Тээврийн хэрэгслийн хулгай	1	0	-1	-100%
Мал хулгайлах	34	38	4	11,7%
Дээрэм	0	1	1	100%
Залилах	5	9	4	80%
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг	1	0	-1	-100%
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	6	7	1	16,6%
Бусад	59	29	-30	-50,8%

Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал



Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал	2019 оны 3 сар	2020 оны 3 сар	Нэгжээр	Өсөлт бууралт /хувиар/
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	6	8	2	33,3%
Эмэгтэй хүн оролцсон	3	3		
Хүүхэд оролцсон	1	0	-1	-100%
Бүлэглэн гүйцэтгэсэн	31	15	-16	-51,6%
Согтуугаар	26	17	-9	-34,6%

Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газар, гараг, цаг хугацаа:

Баянхонгор аймагт бүртгэгдсэн 152 гэмт хэргээс 47 буюу 30,9% нь гэр орон сууцанд, 12 буюу 7,8% нь гудамж талбайд, 9 буюу 6% нь олон нийтийн газар, 4 буюу 2,6% нь төрийн байгууллагад, 3 буюу 1,9% нь төрийн бус байгууллагад, 7 буюу 4,6% нь авто замд, 70 буюу 46% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Үйлдэгдсэн гараг:

Үйлдэгдсэн цаг:




Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Энэ хугацаанд нийт 45 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57 нэгжээр буюу 55,8 хувиар буурсан бөгөөд үүнээс 3 буюу 6,6 хувь нь эмэгтэй хүн холбогдон шалгагдсан байна.

3. Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:


Гэмт хэргийн улмаас 148 иргэн хохирч, үүнээс 35 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 28 нэгжээр буюу 44,4 хувиар буурч, 11 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6 нэгжээр буюу 1.2 дахин өссөн байна.



Гэмт хэргийн улмаас 388,0 сая төгрөгийн хохирол учирснаас 54,1 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 14 хувьтай байна.

4. Зөрчлийн мэдээ

Баянхонгор аймагт 2020 оны I улиралд 5578 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 91 нэгжээр буюу 1,6 хувиар өссөн байна. Зөрчлийг ердийн журмаар /бэлэн бус торгуулийн арга хэмжээгээр/ 4929 зөрчлийг 91.730.9 мянган төгрөгөөр, 510 зөрчлийг хялбаршуулан шалгах журмаар шийдвэрлэж 99.820.0 мянган төгрөгөөр, зөрчлийн хэрэг нээн шалгасан 139 зөрчлийг 1.905.000 төгрөгөөр торгож ажилласан байна.



76 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь 13 нэгжээр буюу 20,6 хувиар, 139 зөрчлийг торгож, эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10 нэгжээр буюу 7,7 хувиар тус тус өссөн байна.

Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилтэй харьцуулсан эзлэх хувь:

Зөрчил гарсан цагаар нь:		Зөрчил гарсан өдрөөр нь:	
		Даваа гараг	865 буюу 15.5%
		Мягмар гараг	901 буюу 16,1%
		Лхагва гараг	848 буюу 15,2%
		Пүрэв гараг	896 буюу 16%
		Баасан гараг	823 буюу 14,7%
		Бямба гараг	616 буюу 11%
01-05 цагт	158 буюу 2.8%	Ням гараг	629 буюу 11.2%

Энэ хугацаанд 302 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр буюу 1,6 хувиар буурсан байна. Эрүүлжүүлэгдсэн хүний 12 буюу 3.9 хувь нь эмэгтэй хүн эзэлж байна.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**